

ХЭЛНИЙ НЭГЖҮҮДИЙН ХУВИРГАЛААР ОЮУТНЫ БҮТЭЭЛЧЭЭР СЭТГЭЖ, НАЙРУУЛАН БИЧИХ ЧАДВАРЫГ ДЭМЖИХ БОЛОМЖ

Ц. Оюунчимэг, доктор, МУБИС

Abstract

“Transformation” means “transformation” or “change” in latin and it is proceeding that changes and transforms the core structure which is “the basic model” of language into the second structure.

Transformation of the language units is connected with the human mental skills tightly on understanding the meaning of words and phrases deeply, imagining and abstracting while combining with other items. And also it is connected with the skills of reading and listening comprehension, receiving and summarizing, think correctly in the native language and express ideas, opinions and feelings in written and oral forms appropriately. Transformation with the aim to create new ideas like adjusting, making similar, increasing, decreasing, and widening is a creative method. For example, in the Mongolian poetry, the experiment of the usage of the word “wind” differently (урьхан хонгор салхи, туулайн гүйдэл шиг салхи, суусар салхи, тал нутгийн ноён салхи, монголын үнэртэй салхи, гэлдрээ цагаан салхи) becomes a fact that creates word picture with new ideas from one side, and from the other side, it expresses the way that can express characteristics of “wind” using different variation of language saying.

Creative thinking is tended to build a new idea and it is different by its speciality, flexibility and word picture. Adjusting, simile, increasing, decreasing, widening and transforming that have the purpose to have a new idea is a creative thinking method (Purev-Ochir and others, 2013. p.90-91).

We can say that creative thinking is a skill to choose the only right variation by making us see problems from different sides, focus on our resources and decide all the variations that exist. We do it through the ways as comparing, analysing and concluding the variations above. By developing their creative thinking, learners receive new knowledge based on their old basic knowledge, analyse and conclude the new knowledge, and furthermore change their views.

Creative thinking itself is connected with language transformation tightly. In other words, language transformation is created by the result of creative thinking.

Түлхүүр үг

Хэлний хувиргал, бүтээлч сэтгэлгээ, найруулан бичих чадвар

Удиртгал

Боловсролын шинэчлэлийн хүрээнд багш бэлтгэх сургалтын чанарыг сайжруулах зорилтуудын нэг нь оюутан суралцагчдын эх хэлний хэрэглээний чадварыг сайжруулах явдал бөгөөд өөрийгөө зөв илэрхийлэх нь харилцах, хамтран суралцах, нийгэмшихүйн хөгжлийн чухал хүчин зүйл болно.

Хэлийг зөв зохистой хэрэглэх чадамж, харилцааны соёл, үг хэллэгээр бусдыг хүндэтгэх ёс, санаа бодлоо ойлгомжтой илэрхийлэх чадвар нь багш мэргэжилтний үнэт зүйл, соёлын чухал хэмжүүрийн нэг болох тул яриа, бичгийн боловсролыг дээшлүүлэх зорилт нь шинэ зууны багшийн бэлтгэл, ур чадвар, үүрэг хариуцлага, үлгэр дуурайлтай салшгүй холбоотой юм.

Хэлний утгат нэгжүүдийг хувиргаж сурснаар суралцагч асуудалд бүтээлчээр ургуулан бодож, олон хувилбарт боломжийг эрж хайсны дүнд тэдгээрээс оновчтой хувилбарыг сонгох чадвартай болох тул хэлний утгат нэгжүүдийг хэлэхүйн зорилго, холбосон орчноос үүтгэн, янз

бүрээр “хөдөлгөн” хувиргах арга нь харилцааны үндсэн нэгж болох өгүүлбэр, эх зохион найруулахад ихээхэн ач холбогдолтой.

Чухам ийм шалтгаанаар хэлний нэгжүүдийн “хөдлөнгө” тал болох хувиргалыг хэлний хэрэглээ, соёлтой холбон, ЕБС-ийн эх хэлний боловсролын стандарт, хөтөлбөр төдийгүй Багш бэлтгэдэг сургуулийн хөтөлбөрт оруулсан байна.

Хэлний нэгжүүдийг хувиргах нь суралцагчдаас бичих зүйлээ сайтар ойлгосон байх, үг хэллэгийн холбоо, түүнээс гарах утга чанарыг мэдэрч, ухаарсанбайхыг шаарддаг хэлэхүйн бүтээлч үйл болно. Эх хэлний боловсролын стандарт, сурах бичигт хэлний нэгжүүдийг хувиргах аргын талаар оруулсан нь дэвшилтэй ч түүнийг хэрэглээ болгох-суралцагчдын найруулан бичих чадварыг сайжруулах сургалтын арга, хэрэглүүр болгож, үр дүнтэй ашиглаж хараахан чадахгүй байгаа юм. Архангайн Багшийн сургуулийн 3 дугаар ангийн

48 оюутнаас найруулан бичих чадварын түвшин тогтоох шалгалтыг хувирган найруулж бичих даалгаврын гүйцэтгэлээр авч үзэхэд дундаж нь 49% байгаа нь хэлний зогсонги тал буюу хэлзүйн дүрэм тодорхойлолт их судалж, хөдлөнгө тал болох утга хэрэглээтэй сайтар холбохгүйгээс шалтгаалж байна.

Багш мэргэжлээр суралцаж буй оюутнуудад хэлний хувиргал, түүний мөн чанар, хувиргалын аргын талаарх суурь ойлголтыг таниулахтай холбогдох гарын авлага, хэрэглэгдэхүүн ч дутмаг байна. Хувиргалыг хэлний утгат нэгжүүдийн хэрэглээтэй холбон, өгүүлбэр, эхэд үг хэллэг нэмж дэлгэрүүлэх, урвуугаар хасаж хураах, бүтээвэр юм уу үг (лексем)-ийг нөгөөгөөр нь сольж сэлгэх, гишүүдийн байрыг тонгоргох гэсэн байдлаар хувиргаж байгаагийн цаад зорилго нь эцсийн эцэст хэлний хэрэглээнд сургах, хэлний нэгжүүдийг холбосон орчин, хам хүрээллийн дотор оновчтой сонгож хэрэглэх чадвар дадал эзэмшүүлэхэд чиглэж байгаа юм.

Иймд багш бэлтгэдэг сургуулийн оюутнуудад хувиргалын мөн чанар, хувиргалын аргуудыг таниулж, тогтолцоо бүхий дасгал даалгавраар бичих үйлийг алхам дарааллаар дэмжих нь суралцагчдын найруулан бичих чадварын хөгжилд чухал нөлөө үзүүлнэ. Хэлний нэгжүүдийн хувиргал, түүний мөн чанар, хувиргах аргыг эх хэлний сургалтын агуулга, аргазүйтэй холбон судалсны үндсэнд оюутны найруулан бичих чадварыг дэмжих аргазүйн хувилбар боловсруулан туршиж, үр дүнг тооцох зорилготой болно.

Хувиргал нь хэлний утгат нэгжүүдийн түвшин бүрд харилцан адилгүйг үндэслэн, хувиргал тус бүр найруулан бичих үйлтэй хэрхэн холбогдож байгааг тодорхойлох, оюутны найруулан бичих чадварыг дэмжих аргазүйн хувилбар боловсруулж туршин, үр дүнг тооцох судалгааг хийсэн болно.

Судлагдсан байдал

1950-аад оны дунд үеэс товчоолох хэлшинжлэлийн хувьсах аргад үндэслэсэн энэхүү онолыг Н. Хомский үүсгүүр хэлзүйн хувьсах загвар (*хэлийг загварчлах*) болгон хөгжүүлснээр хувиргал хэлзүй гэсэн нэр томъёог хэлшинжлэлд хэрэглэх болсон байна.

Хэлний нэгжүүдийн хувиргал нь тодорхой аргаар дамжин хэрэгждэг бөгөөд эрдэмтэн судлаачид янз бүрээр тооцож гаргасан байдаг. Эрдэмтэн Э.Равдан “Бүтэц хэлшинжлэл” (2000. х.142), Г.Жамбалсүрэн “Монгол хэлшинжлэлийн онолын зарим асуудал, хэлний нэрлэх, мэдээлэх, харилцах дохио” (1987, х.56), М.Базаррагчаа “Орчин цагийн монгол хэлний энгийн өгүүлбэр” (1993. х.98-104), Б.Пүрэв-Очир “Монгол хэлний

энгийн ба нийлмэл өгүүлбэрийн хувиргал” (2006. х.9), С.Нямсүрэн “Хэл хэлэхийн учир” (1974. х.76) зэрэг бүтээлдээ хэлний хувиргалын аргын талаар судалсан бол эртний хэлзүйчдээс Чойжи-Одсэр, ХҮУ зууны үеийн хэлмэрч Шаравсэнгэ, ХҮҮ- ХҮШ зууны үеийн нэрт орчуулагч Гүүш цорж, ХҮШ зууны үед орчуулагч Дай гүүш Агваандампил тэргүүтэн бичгийн мэргэд зохиол бүтээлдээ хувирган найруулах аргыг бүтээлчээр ашиглаж байсан уламжлалтай байна. Мөн нэг хэлнээс нөгөө хэлэнд орчуулга хийхэд хувиргалын аргыг хэрэглэх боломжийн талаар Г. Аким, Л.С. Бархударов (1975. с.190-231), Я.И. Рецкер (1981. с.38), Л.К. Латышев (Рецкер, 1981. с.131-137), А.М. Фитерман, Т.Р. Левицкая (1973) нар судалсан байна.

Судалгааны хамрах хүрээ

МУБИС-ийн Архангай дахь Багшийн сургуулийн Бага боловсролын багшийн 3-р ангийн 48 оюутан

Судалгааны арга

- I. Мэдээ баримт цуглуулсан арга
 - Эх материалтай ажиллах аргыг хувиргал, түүний мөн чанарыг тодруулах үүднээс хэлний хувиргалын талаарх эрдэмтдийн санал тайлбар, судалгааг судлахад;
 - Сургалтын баримт бичиг (ЕБС-ийн стандарт, хөтөлбөр болон Багш бэлтгэх сургуулийн сургалтын хөтөлбөр)-т хувиргал айг хэрхэн судлахаар оруулсныг тодруулахад;
- II. Мэдээ баримтыг боловсруулсан арга
 - Асуулгын аргыг хэлний нэгжүүдийн хувиргалыг сургалтад ашиглаж байгаа болон агуулга, цагийн багтаамж, хэрэглээний талаар оюутнуудаас судалгаа авч үр дүнг задлан шинжлэхэд;
 - Үйлийн судалгааны аргыг хэлний нэгжүүдийн хувиргалын тогтолцоот даалгавраар оюутны найруулан бичих чадварыг дэмжих аргазүйн хувилбарыг хэрэгжүүлэхэд;
 - Тоон боловсруулалтыг туршилт судалгаанд хамрагдсан оюутнуудын найруулан бичих чадварын хөгжлийн эхний болон эцсийн, ахицын түвшинг жишиж харьцуулан, үр дүнг тооцоход тус тус ашигласан болно.

Үндсэн хэсэг

Хэлний нэгжүүдийн хувиргал нь хэлэхүйн тал буюу хөдлөнгө шинжтэй холбоотой учраас найруулан бичих чадвар, хэлний нэгжүүдийн утга, найруулгын өнгө аяс, хэрэглээтэй ямар

хамааралтай байгааг судлуулж байгаа юм. Хэлний хувиргал, хувиргах аргын талаарх эрдэмтэн судлаачдын санал дүгнэлтийг харьцуулан үзэж, сургах аргагүйг боловсруулахад суурь болж буй гол ойлголтыг дараах байдлаар тодорхойлсон болно.

- Хувиргал - Мэдээллийн цөм бүтцэд тулгуурлан түүний гүн бүтэц буюу агуулгыг өөрчлөхгүйгээр өнгөн бүтэц буюу хэлбэрийг хувиргаж, өөр нэгэн хувилбар үүсгэхийг хэлнэ.
- Хувиргах арга- Хэлний нэгжүүдийн хувиргалыг олон талаас нь судалсаар ирсэн боловч аль хувиргалд ямар аргыг оруулж болох талаар санал бага зэрэг зөрүүтэй байна. Иймд эрдэмтдийн судалгаа, тайлбарыг үндэс болгон урвуулах, салаалах, тонгоргох, ерөнхийлөх хувиргалд харгалзах дараах аргууд байна гэж үзлээ. Хэлний нэгжүүдийн хувиргал нь найруулан бичих үйлтэй ямар хамааралтай байгааг авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт 1


Хэлний нэгжүүдийн хувиргал-найруулан бичих чадварын хамаарал

Хувиргал	Найруулан бичих чадварын хөгжил
Салаалах (сэлгэх)	<ul style="list-style-type: none"> • Үг хэллэгийн ойролцоо болон төсөө хувилбаруудыг ашиглан, тэдгээрээс сонгож найруулах буюу найруулгад бүтээвэр, үг хэллэгийг оновчтой сонгон бичих үндэс болно. • Үгсийн учирзүйн холбоог таних
Тонгоргох (солих)	<ul style="list-style-type: none"> • Эх, өгүүлбэрийн мэдээллийн бүтцийг өөрчлөх, утга санааг онцлох, ялгах, эсрэгцүүлэх, нэршүүлэх, үйлшүүлэх байдлаар найруулан бичихийн үндэс болно. • Өгүүлбэр, эхийн бүрдэл хэсгийн холбох хэрэглүүрийг зөв сонгон, оновчтой найруулж бичих чадвар хөгжинө.
Урвуулах (нэмэх) (хасах)	<ul style="list-style-type: none"> • Хэлзүйн үг, өгүүлбэрийн холбох хэрэглүүрийг зөв хэрэглэх • Цөм бүтэц, хураангуй хэллэг, гол санааг тулгуур болон түлхүүр үг хэллэгээр дэлгэрүүлэн найруулж бичих • Цөм бүтцийг таних, гол санааг гол бусаас ялгах • Гол санааг хэлц нэгжээр илэрхийлж, хураангуйлж сурах • Товчлон найруулж бичих үндэс суурь нь болно.
Ерөнхийлөх	<ul style="list-style-type: none"> • Эх, цогцолбор, эхийн цөм бүтцийн утга санааг өөрчлөхгүйгээр хэв маягийг өөрчилж, утга, хэлбэрийн хувьд зөв хэлбэржүүлэн, холбон найруулж бичихийн үндэс болно.

Хэлний нэгжүүдийг хувиргах, зөв зохистой найруулан бичих үйл нь хэлэхүйтэй салшгүй холбоотой бөгөөд хэлэхүйн гадаад илрэл болно.

Загвар 1

Хэлэхүй-хувиргал - хэл-найруулан бичих үйл



Зөв сайхан найруулан бичих нь:

- Үгийг оновчтой сонгох (нэг утгаар давтахгүй байх)
- Хэлзүйн хэрэглүүрийг оновчтой сонгох (олон давтахгүй байх)
- Учирзүйн зөв дараалалтай байх (үгийг зөв

байрлуулах, өгүүлбэр, цогцолборын утга санааг зөв ухаарах)

- Цөм санааг оновчтой илэрхийлсэн (сэдэв, агуулга тохирох) байхыг хэлэх бөгөөд А.Эйнштейн “Сайхан найруулдаг болохын тулд уйгагүй сурч, мэдлэгээ цаг ямагт тэлж, сэтгэхүйгээ хөгжүүлж байх нь зайлшгүй шаардлагатай. Аливаа зүйлийг гярхай ажиглаж, утга учрыг гүн ухаарч, ургуулан боддог чадвар эзэмших ёстой” гэжээ.

Чадвар нь аливаа зүйлийг өндөр чанартай, өнгө үзэмжтэйгээр богино хугацаанд хийж гүйцэтгэхэд шаардагдах үйл ажиллагааны бүрдэл хэсэг бөгөөд чадварын үндэс нь үйлийг алдаагүй, уян хатан ухаалаг байдлаар гүйцэтгэж найдвартай үр дүнд хүрсэн байх явдал юм (Доржжав, 2005. х.104).

Иймд суралцагчдын найруулан бичих чадварыг сайжруулахад хэлний нэгжүүдийн хувиргалтай холбоотой дасгал даалгаврыг

тодорхой алхам дарааллаар, уялдаа холбоотой цогц байдлаар хийлгэж, асуудалд олон талаас нь хандаж, боломжит хувилбарыг гарган, хам сэдэвт тохируулан хамгийн оновчтойг сонгох чадварт сургах нь чухал юм. Хэлний нэгжүүдийн хувиргалын сэтгэлзүй, сурган хүмүүжүүлэх зүйн үндсийг үзэв. Хувиргал нь сэтгэхүйн хөдлөнгө, уян хатан олон үйлдлийн үр дүн бөгөөд хэлний нэгжийг элдэв янзаар хувиргаж, хэлэхүйн олон боломжийг “нээж буй” бүтээлч үйл болно. Найруулан бичиж сурах үйл нь эмх цэгцтэй, логик дэс дараатай ярихаас мэдрэгдэх бөгөөд энэ нь угтаа бүтээлч сэтгэхүйн хөгжилтэй холбоотой юм. Өөрөөр хэлбэл, хэлний хөдлөнгө тал болох хэлэхүй-хувиргал нь бүтээлчээр сэтгэх (анализ, синтез, харьцуулах, хийсвэрлэх, тодруулах) чадвартай салшгүй холбоотой тул хувиргалын сэтгэлзүйн үндэс нь бүтээлч сэтгэлгээ болно.

Хэлийг харилцааны хэрэглүүр болгож, зөв хэрэглэх гэдэг нь уншсан, сонссоноо ухаарч ойлгох, хүртэж хүлээн авч эргэцүүлэн бодох чадвараас эхлээд, эх хэлээрээ зөв сэтгэх, санаа бодол, мэдрэмж, сэтгэгдлээ ам ба бичгээр оновчтой илэрхийлэх чадварыг хэлнэ. Хэлний нэгжүүдийн хувиргалаар суралцагчдын найруулан бичих чадварыг хөгжүүлэх аргачлалыг боловсруулж туршигдаа Ж.Пиаже, Л.С.Выготский нарын үндэслэсэн конструктивизмын онол, тодруулбал, хүн мэдлэгээ өөрөө зохиомжлон бүтээдэг гэсэн санааг үндэс болгов. Өөрөөр хэлбэл, хэлний нэгжүүдийн хувиргалаар суралцагчдын найруулан бичих чадварыг хөгжүүлэхдээ хэлний түвшин, хувиргалын онцлогийг харгалзан уялдаа холбоотой шаталсан даалгавар гүйцэтгэн, мэдээллийн цөм бүтцийг ухаарч ойлгох, нээлт хийх, өөрчилж хувиргах, оновчтой хувилбарыг сонгох, шийдэх боломж олгох нь чухал юм. Суралцагчдын мэдлэг чадварт тулгуурлан хэлний утгат их бага нэгжүүдийг холбосон орчин, хам


хүрээллийн дотор янз бүрээр хувиргаж, үүний үр дүнд найруулан бичих үйлийг ЭРГЭЦҮҮЛЭЛ-ХУВИРГАЛ-СОНГОЛТ-ШИЙДЭЛ гэсэн дараалалд бүтээлчээр гүйцэтгэх нь аргазүйн гол үндэс болно.

Судалгаа аргазүй

Хэлний хувиргалын тогтолцоот даалгавраар оюутны найруулан бичих чадварыг дэмжих аргазүйн хувилбарыг боловсруулсан бөгөөд бүтцийг харуулбал:

Загвар 2

Хувиргалын тогтолцоот даалгавраар оюутны найруулан чадварыг дэмжих аргазүйн бүтэц




Зорилго: Хэлний хувиргалын агуулгын бүтцийг өөрчлөн, тогтолцоот даалгавар, даалгаврыг гүйцэтгэх аргачлал боловсруулан, туршиж үр дүнт тооцох

Агуулга: Эх хэлний боловсролын стандарт (2004), хөтөлбөрт УТГА- БҮТЭЦ- ХУВИРГАЛ- СОЁЛ гэж нэг ай болгож, эх, өгүүлбэр, үг, бүтээврийг дэлгэрүүлэх, хураах, тонгоргох, салаалах гэж тусгасныг дараах байдлаар өөрчилсөн.

Загвар 3

Хувиргал айн агуулгын бүтцийн өөрчлөлт



**Хэрэглэгдэхүүн-тогтолцоот даалгаврын боловсруулалт**

Сургах туршилтад оюутны ажиллах дасгал даалгаврыг Марзано, Кендалл нарын Шинэ таксономыг баримжаалан, хувиргалын хэлбэрүүдийн хөнгөнөөс хүндрэх дарааллаар, харилцан уялдаатай боловсруулсан учраас эдгээр нь тогтолцоот шинж чанартай болж байна.

Хүснэгт 2

Тогтолцоот даалгаврыг Шинэ Таксономын түвшнээр авч үзвэл,

Найруулан бичих чадвар	Даалгаврын түвшин				
	Сэргээн санах	Утга өгөх	Анализ хийх	Мэдлэгээ хэрэглэх	Метакогнитив
	Дасгал даалгаврууд				
Хэлзүйн хэлбэр сонголт	1	2.3.4.5	6.7.8	9.10	
Хэлзүйн үгийн сонголт			11.12	13.14	15.16.17
Учирзүйн дараалалтай бичих	18.19.20.21	22.23.24.25.26	27	28.29.30.31	32.33.34.35
Цөм санааг илэрхийлэл				36	37.38.39.40
Нийт	5	9	6	9	11

Тогтолцоот даалгаврыг гүйцэтгэснээр оюутан дараах чадвар эзэмшинэ. Хүснэгт 3-т харуулав.

Хүснэгт 3

Хэлний талаас	Сэтгэхүйн талаас
Урвуулах (дэлгэрүүлэх) хувиргал	
<ul style="list-style-type: none"> • Үгийн нөөц нэмэгдэх • Тухайн зүйлийг олон талаас нь эргэцүүлэн бодож, харьцуулан жишиж <u>эх зохион найруулж бичих чадвартай</u> болж хөгжих 	<ul style="list-style-type: none"> • Бүхэл зүйлийг олон талаас нь харах • Задлан шинжлэх, төсөөлөх, хийсвэрлэх, ургуулан бодох
Урвуулах (Хураах)	
<ul style="list-style-type: none"> • Зөв сэтгэж, санаагаа товч, тодорхой, оновчтой илэрхийлэх • Онцолбор мэдээллийг дэвсвэр мэдээллээс ялган санааг товч тодорхой илэрхийлж бичих • Хэлний хувьсан өөрчлөгдөх хэлний дотоод зүй тогтлыг мэдрэх 	<ul style="list-style-type: none"> • Тухайн зүйлийн аль нэг шинжийг өөр юманд байгаа тухайн шинжид тулгуурлан төсөөлөх, харьцуулан жиших, нэгтгэн дүгнэх
Салаалах	
<ul style="list-style-type: none"> • Үг хэллэгийн учирзүйн холбоог таньж ухаарах • Ойролцоо утгатай бүтээвэр, үг хэллэг, хэлц нэгжийн утгын нарийн ялгамжийг мэдэрч найруулгад зөв сонгох • Найруулгад үгийг оновчтой сонгох • Өгүүлбэр, эхийн гол санааг ухаарч ойлгоно. Өөрөөр хэлбэл, “их унших биш, зөв унших” чадварт суралцаж байна.. 	<ul style="list-style-type: none"> • Жишин харьцуулах, хийсвэрлэх, ялгах мэдрэмж
Тонгоргоох	
<ul style="list-style-type: none"> • Холбох үгийн үүрэг, хэрэглэгдэх орчныг мэдэрч, өгүүлбэр, эхийн бүрдэл хэсгийг зөв холбох • Өгүүлбэр, эхийн цөм санаа болон онцолбор, дэвсвэр мэдээллийг ялгах 	<ul style="list-style-type: none"> • Мэдээллийн чухлыг чухал бусаас ялгаж, боловсруулалт хийх • Хэлний мэдрэмжтэй болно. Өөрөөр хэлбэл, өгүүлбэр эх дэх хэлзүйн үг, өгүүлбэр, цогцолборыг хөдөлгөх нь хэлзүйн хэлбэржилт, үг, холбох хэрэглүүрээс хамгийн оновчтойг нь богино хугацаанд хурдан сэтгэж олох, онцолбор мэдээлэлд тулгуурлан оновчтой сонгон найруулж бичих чадвартай болж байна.
Ерөнхийлөх	
<ul style="list-style-type: none"> • Холбох үгийн үүрэг, хэрэглэгдэх орчныг мэдэрч, нийлмэл өгүүлбэр, эхийн бүрдүүлэгч хэсгийг зөв холбох • Найруулгын төрөл, эхийн хэв маягийн ялгамжийг ухаарах 	<ul style="list-style-type: none"> • Харьцуулах, хийсвэрлэх, жишиж адилтгах, нэгтгэн дүгнэх чадвар

Оюутны найруулан бичих чадварыг үнэлэх шалгуур: Хэлний нэгжүүдийн хувиргал нь ЭРГЭЦҮҮЛЭЛ-ХУВИРГАЛ-СОНГОЛТ-ШИЙДЭЛ гэсэн үйлээр дамжин хэрэгждэг, найруулан бичих чадвар нь хэлзүйн хэрэглүүр, үгийн сонголт, өгүүлбэр, эхийн бүрэлдүүлбэрүүдийн байр дэс дарааг оновчтой сонгосноос хамаардаг. Иймд оюутны гүйцэтгэлийг эхний түвшинд боломжит бүх хувилбарыг гаргаж чадсан эсэхийг харгалзан үнэлж дүгнэнэ.

Хүснэгт 4

Оюутны найруулан бичих чадварыг үнэлэх шалгуур үзүүлэлт


№	Шалгуур	Чанарын үзүүлэлт	Тоон үзүүлэлт
1	Хэлзүйн хэлбэр сонголт (30 оноо)	11 боломж	1 нь 1 оноо, нийт 11 оноо
		Ойролцоо утгатай үгсийн үүр үүсгэж чадсан	5
		Ойролцоо утгатай үгсийн үүрийг дутуу үүсгэсэн	4
		Үүр болгохдоо зарим үгийг буруу сонгосон	3
		Үүр болгохдоо ихэнх үгийг буруу сонгосон	1
		Хам сэдэвт оновчтой хувилбарыг олж чадсан	2
		Оновчтой хувилбараар сэлгэн, сонгосон хувилбарын утгыг онолын үндэстэй тайлбарласан	2
		Сонгосон хувилбарыг өөрийн санаагаар дөхүүлж тайлбарласан	1
		Сонгосон хувилбарыг дутуу тайлбарласан	1
		Ойролцоо утгатай үгсийн үүр буруу үүсгэсэн, сонгосон хувилбарыг тайлбарлаагүй	0
2	Хэлзүйн үг сонголт (30 оноо)	10 боломж	1 нь 1 оноо, нийт 10 оноо
		Ойролцоо утгатай үгсийн үүр үүсгэж чадсан	5
		Ойролцоо утгатай үгсийн үүрийг дутуу үүсгэсэн	4
		Үүр болгохдоо зарим үгийг буруу сонгосон	3
		Үүр болгохдоо ихэнх үгийг буруу сонгосон	2
		Хам сэдэвт оновчтой хувилбарыг олж чадсан	1
		Оновчтой хувилбараар сэлгэн, сонгосон хувилбарын утгыг онолын үндэстэй тайлбарласан	2
		Сонгосон хувилбарыг өөрийн санаагаар дөхүүлж тайлбарласан	2
		Сонгосон хувилбарыг дутуу тайлбарласан	1
		Ойролцоо утгатай үгсийн үүр буруу үүсгэсэн, сонгосон хувилбарыг тайлбарлаагүй	0
3	Учирзүйн дараалал (25 оноо)	9 боломж	1 нь 1 оноо, нийт 9 оноо
		Хэлзүйн хэлбэржилт, холбох хэрэглүүрийг оновчтой сонгосон	5
		Хэлзүйн санамсаргүй гаргасан алдаа нь найруулгад нөлөөлөхгүй	4
		Бүх хувилбарт учирзүйн алдаа гаргаагүй	4
		Зарим хувилбарт учирзүйн алдаа гаргасан	2
		Ихэнх хувилбарт учирзүйн алдаа гаргасан	1
		Буруу байрлуулснаас онцолбор мэдээлэлд нөлөөлсөн.	0
4	Цөм санааны илэрхийлэл (15 оноо)	Дараалал зөв, цөм санааг олж чадсан	7
		Дараалал дутуу боловч цөм санааг олж чадсан	5
		Дараалалтай хураах гэж оролдсон, цөм санааг олж чадсан	2
		Дараалалгүй боловч цөм санааг дөхүүлсэн	1
		Дараалалгүй, цөм санааг олж чадаагүй	0
		Нийт оноо	100

Үнэлгээний хэмжээс: Оюутны даалгаврын гүйцэтгэлийн 70-аас дээш үзүүлэлтийг хангалттай, 70-аас доош үзүүлэлтийг хангалтгүй гэж үзэн шалгуур үзүүлэлтийн дагуу найруулан бичих чадварын ахицад хийсэн шинжилгээг хийвэл:

Хүснэгт 5
Оюутнуудын найруулж бичих чадварын ахицын судалгаа

Хугацаа	Эхний түвшин				Явцын				Эцсийн түвшин			
	хангалттай		хангалтгүй		хангалттай		хангалтгүй		хангалттай		Хангалтгүй	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	Хувь
Хэлзүйн хэлбэрийн сонголт	16	33.3	31	64.5	27	56.2	12	25	47	97.9	1	2.08
Хэлзүйн үгийн сонголт	17	35.4	32	66.6	26	54.1	22	45.8	48	100		
Учирзүйн дараалал	13	27.0	35	72.9	39	81.2	9	18.7	46	95.8	2	4.1
Цөм санааны илэрхийлэл	30	62.5	18	37.5	40	83.3	15	31.2	45	93.7	3	6.2

Туршилтын дараах үеийн чадварыг эхний түвшний чадвартай харьцуулбал,

График 1
Хувирган найруулж бичих чадварын ахиц

Дүгнэлт

- Хэлний утгат нэгжүүдийн хувиргал нь хэлэхүйн буюу хөдлөнгө талтай, тухайлбал, санааг дэлгэрүүлэх ба ялгах, утгын нарийн ялгамжийг мэдэрч ухаарах, нэгтгэн ерөнхийлөх, олон хувилбараас сонгох зэргээр хэлний нэгжүүдийн утга, найруулгын өнгө аяс, хэрэглээтэй шууд холбоотой учир бага дунд боловсролын эх хэлний боловсролын стандарт, багш бэлтгэх сургалтын хөтөлбөрт хувиргал ай болгон оруулсан байна.
- Боловсруулсан аргазүйн хувилбарыг туршихад эхний үед оюутнууд хувиргалыг хэлбэрийн өөрчлөлт мэтээр хандсанаас боломжит хувилбаруудыг гаргаж чадахгүй байх, эмх цэгцгүй хувиргах; даалгаврын хүнд түвшинд шилжих явцад ерөнхийлөх, тонгоргох хувиргалын даалгаврыг гүйцэтгэхдээ хэлзүйн хэрэглүүрийг буруу сонгох, учир зүйг алдагдуулах зэрэг нийтлэг алдааг гаргаж байсан бол туршилтын хугацаанд асуудалд олон талаас нь хандаж, олон хувилбар гаргахыг хичээх, хувиргахдаа хэлний дотоод зүй тогтолд тулгуурлан эмх цэгцтэй хувирган найруулж бичих, өөрийн бичсэнийг бусдынхтай харьцуулан, өөр боломж байсныг мэдэх, үнэлэх чадвартай болж байгаа нь ажиглагдсан.
- Туршилтын үр дүнгээс үзвэл, хэлний нэгжүүдийн хувиргалтай холбоотой тогтолцоот дасгал даалгаврыг алхам дараалалтай, харилцан хамааралтай, хэлзүйн дүрэм, зүй тогтолд тулгуурлан уялдаа холбоотой хийлгэх нь үр дүнтэй байна.

Тухайлбал, өгүүлбэр, эхийн цөм санааг илэрхийлэн хураан найруулж бичихдээ хэлний нэгжүүд нь нэг нь нөгөөгөө багтаасан шинжтэй байдаг тул өгүүлбэрт байгаа шинж эхэд давтагдаж байдгийг харгалзан алхам дарааллаар ажиллуулахад оюутны хураан найруулж бичих чадвар ахиж байна.

- Хэлний хувиргал нь суралцагчдын найруулан бичих чадварыг дэмжих гол арга гэдгийг аргазүйн хувилбарын сургах туршилтын явц, найруулан бичих чадварын ахиц үр дүн харуулж байна.

Ашигласан материал

- Базаррагчаа, М. (1993). *Орчин цагийн монгол хэлний энгийн өгүүлбэр*. Улаанбаатар
- Бархударов, Л.С. (1975). Структура простого предложения современного английского языка. Москва
- Доржжав, С. (2005). *Сэтгэлзүйд өөрөө суралцах нь*. Улаанбаатар
- Жамбалсүрэн, Г. (1987). *Монгол хэл шинжлэлийн онолын зарим асуудал, Хэлний нэрлэх, мэдээлэх, харилцах дохио*. Улаанбаатар
- Нямсүрэн, С. (1974). *Хэл хэлэхийн учир*. Улаанбаатар
- Пүрэв-Очир, Б. (2006). *Монгол хэлний энгийн ба нийлмэл өгүүлбэрийн хувиргал*. Улаанбаатар
- Равдан, Э. (2000). *Бүтэц хэл шинжлэл*. Улаанбаатар
- Рецкер, Я.И. (1981). *Учебные пособия по переводу с английского языка, на русский*. Москва